



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 79

Ховд

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Үндэсний Их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны “Ойн баяр наадмыг зохион байгуулах хороо байгуулах тухай” 35 дугаар тогтоолын 1,2 дугаар хавсралтад заасан зохион байгуулах хороо, салбар хорооны бүрэлдхүүнд дараахь өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:

1./ Ойн баяр наадмыг зохион байгуулах хороонд:

Дарга:	Ч.Чинбат	- Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Д.Дэлгэрбаяр	- Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн дарга
Гишүүн:	Д.Бат-очир	- Аймгийн ЗДТГ-ын ХБХ-ийн дарга

2./ Үндэсний Бөхийн барилдаан зохион байгуулах салбар хороонд:

Нарийн бичгийн дарга:	Б.Банзрагч	- Аймгийн БТСГ-ын дарга
-----------------------	------------	-------------------------

3./Хурдан морьдын уралдаан зохион байгуулах салбар хороонд:

Нарийн бичгийн дарга:	А.Эрдэнэчулуун	- Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга
Гишүүн:	Б.Ганзориг	- Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, МСУХ-ны гишүүн

Б.Дүгэржав - Аймгийн ИТХ-ынТөлөөлөгч,  
МСУХ-ныгүйцэтгэх захирал

Т.Шинэбаяр -Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч,  
“Ачзаяа “эмнэлгийн ерөнхий эмч

4./ Сурын харваа зохион байгуулах салбар хороонд:

Гишүүн: Б.Баттүвшин - Аймгийн ИТХ-ын Ажлын албаны  
ЭЗҮӨХХ-ийн мэргэжилтэн

Нарийн бичгийн  
дарга: Ч.Түмэндэмбэрэл -БТСГ-ын Спортын сургалт  
хариуцсан албаны дарга

Д.Октябрь - Аймгийн Цагдаагийн газрын  
ахлах хэрэг бүртгэгч

5/ Урлаг спортын асуудал хариуцсан салбар хороонд:

Дарга: М.Баатар - Аймгийн ХДТ-ын дарга

Гишүүн: А.Алтангэрэл - Аймгийн БСГ-ын соёл хариуцсан  
мэргэжилтэн

Д.Ган-Очир - Аймгийн БСГ-ын орлогч дарга

6/ Хэв журмын асуудал хариуцсан салбар хороонд:

Дарга: С.Цэрэнсамбуу - Аймгийн Цагдаагийн газрын  
дарга, Цагдаагийн хурандаа

2. Ойн баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдхүүнд Үндэсний шагайн харвааг зохион байгуулах салбар хороог нэмж ажиллуулсугай. Үүнд:

7./ Үндэсний шагайн харвааг зохион байгуулах салбар хороо:

Дарга : Ж.Дөлбадрах - Аймгийн Тахарын албаны дарга

Гишүүдэд: Б.Пүрэвдорж – Шагайн холбооны аймгийн  
тэргүүн

Н.Чулуунбаатар – Шагайн холбооны гишүүн

Нарийн бичгийн  
дарга:

Г.Нямчулуун

- Жаргалант сумын Байгаль  
орчны хяналтын улсын байцаагч

Ч.Түмэндэмбэрэл

- БТСГ-ын Спортын сургалт  
хариуцсан албаны дарга

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 80

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Монгол улсын Хүний Гавъяат эмч цол”-оор

1. Төмөр Шинэбаяр - Ая заяа эмнэлгийн мэс заслын эмч
2. Пүрэвдорж Бямбаа - Очир сүлд мэдрэлийн эмнэлгийн эмч
3. Лхасүрэн Дагийсүрэн - БОЭТ-ийн арьс харшлын тасгийн эмч

“Монгол улсын Гавъяат малчин цол”-оор

1. Жадамба Дулам - Чандмань сумын Сүлжээ багийн ахмад  
настан

“Монгол улсын Гавъяат тээвэрчин цол”-оор

1. Цэрэнбуу Төрбат - Чандмань сумын Сүлжээ багийн ахмад  
настан

“Монгол улсын Соёлын гавъяат зүтгэлтэн цол”-оор

1. Рэнцэн Даваажав - Чандмань сумын Урд гол багийн ахмад  
настан

“Эрүүлийг хамгаалахын гавъяат ажилтан цол”-оор

1. Базар Чойсүрэн - ЭМГ-ийн статистик, мэдээллийн мэргэжилтэн

“Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-гоор

1. Санж Бат-Өлзий - ЭМГ-ын ХӨТСТ-ын албаны дарга
2. Дагважанцан Нүрзээ - Чандмань сумын Урд гол багийн ахмад настан
3. Бямбажаргал Балт - Чандмань сумын Талын булаг багийн ахмад настан
4. Сундуй Дамдинжав - Жаргалант сумын Жаргалан багийн ахмад настан
5. Санж Өлзий - Жаргалант сумын Алагтолгой багийн ахмад настан
6. Чүлтэмсүрэн Цэрэнчимэд - Аудитын газрын ахлах шинжээч
7. Дашдорж Уранбилэг - Цаст-Алтай цогцолбор сургуулийн сургалтын менежер
8. Манжил Ягаан - Хан-Хөхий эмийн сангийн эрхлэгч
9. Пүрэвхүү Жаргал - Хос шонхор авто сургуулийн захирал
10. Сэрээтэр Цэрмаа - БОЭТ-ийн сэтгэц наркологийн тасгийн эмч
11. Дүгэр Дашзэвэг - Чандмань сумын талын булаг багийн ахмад настан

“Алтан гадас одон”-гоор

1. Магнай Наадгай - Эрүүл мэндийн газрын ахмад ажилтан
2. Бямбажав Баасанжав - Эрүүл мэндийн газрын ахмад ажилтан
3. Балт Зулхүү - Эрүүл мэндийн газрын ахмад настан
4. Жүрмэд Жавзандулам - Эрүүл мэндийн газрын ахмад ажилтан
5. Нямжав Даваажав - Эрүүл мэндийн газрын ахмад настан
6. Мягмарай Цагаач - Бугат өрхийн эрүүл мэндийн төвийн дарга

- |                           |                                                             |
|---------------------------|-------------------------------------------------------------|
| 7. Езшээ Наранцэцэг       | - БОЭТ-ийн дотрын тасгийн сувилагч                          |
| 8. Самданхүү Сүрэнхүү     | - БОЭТ-ийн хоол зүйч их эмч                                 |
| 9. Цэгмид Даваажав        | - Эрүүл мэндийн газрын жолооч                               |
| 10. Дамдинсүрэн Хишгээ    | - Аудитын газрын ахлах аудитор                              |
| 11. Шавирай Нарантуяа     | - Аудитын газрын аудитор                                    |
| 12. Содном Дорж           | - Аймгийн ЗДТГ-ын нийгмийн хөгжлийн<br>хэлтсийн мэргэжилтэн |
| 13. Ням Өлзий             | - Цэцэг сумын Баянгол багийн ахмад<br>настан                |
| 14. Довчин Дариймаа       | - Цэцэг сумын ЭМТ-ийн лаборант                              |
| 15. Лхагважав Эрдэнэцэцэг | - БОЭТ-ийн мэдрэлийн тасгийн их эмч                         |
| 16. Чойжав Нямаахүү       | - БОЭТ-ийн чанарын албаны дарга                             |
| 17. Лхагва Цэцэгсүрэн     | - БОЭТ-ийн ерөнхий сувилагч                                 |
| 18. Жаргал Ганхуяг        | - БОЭТ-ийн мэс заслын эмч                                   |
| 19. Цэдэв Ичинхорлоо      | - Жаргалант сумын Магсаржав багийн<br>ахмад настан          |
| 20. Сунгарав Хүрэлбаатар  | - Жаргалант сумын Магсаржав багийн<br>ахмад настан          |
| 21. Данаажав Адилбиш      | - Чандмань сумын Урд гол багийн ахмад<br>настан             |
| 22. Намжил Лхагваа        | - Жаргалант сумын Тахилт багийн ахмад<br>настан             |
| 23. Ёндонсамбуу Пүрэв     | - Чандмань сумын ахмад настан                               |

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар

- |                       |                                                        |
|-----------------------|--------------------------------------------------------|
| 1. Даржаа Баасанхорол | - Жаргалант сумын иргэн                                |
| 2. Хожиг Батчулуун    | - Жаргалант сумын Баатархайрхан багийн<br>ахмад настан |
| 3. Найдан Түвшин      | - Жаргалант сумын Алагтолгой багийн<br>ахмад настан    |
| 4. Ойдов Дорьдовсүрэн | - Жаргалант сумын Алагтолгой багийн<br>ахмад настан    |
| 5. Жаргал Цэнджав     | - Жаргалант сумын Алагтолгой багийн<br>ахмад настан    |

- |                             |                                                        |
|-----------------------------|--------------------------------------------------------|
| 6. Хамбаа Батчулуун         | - Жаргалант сумын Алагтолгой багийн иргэн              |
| 7. Дамчуу Энгээ             | - Жаргалант сумын Алагтолгой багийн<br>ахмад настан    |
| 8. Сэнгээ Пүрвээ            | - Жаргалант сумын Бичигт багийн<br>ахмад настан        |
| 9. Сумхүү Чойжилжав         | - Жаргалант сумын Алагтолгой багийн<br>ахмад настан    |
| 10. Лханаа Тунгалаг         | - Чандмань сумын Хүн эмнэлэгт ээлжийн<br>сувилагч      |
| 11. Совд Бадамцэцэг         | - Чандмань сумын Тахилт багийн эмч                     |
| 12. Бизъяа Оюунцэцэг        | - Чандмань сумын Хүн эмнэлэгт эх баригч                |
| 13. Базар Цэцэгмаа          | - Чандмань сумын эмийн сангийн эрхлэгч                 |
| 14. Будлай Түмэнжаргал      | - Чандмань сумын хүн эмнэлгийн жолооч                  |
| 15. Цэнд-Аюуш Мөнхцэцэг     | - Эрүүл мэндийн газрын ЭЗУМХ-ийн дарга                 |
| 16. Гармаа Долгор           | - БОЭТ-ийн сувилагч                                    |
| 17. Түдэв Цагаан            | - БОЭТ-ийн дурангийн их эмч                            |
| 18. Даваажав Баярмандал     | - БОЭТ-ийн эмгэг судлалын тасгийн их эмч               |
| 19. Хонгоршар Алимаа        | - БОЭТ-ийн мэс заслын тасгийн үйлчлэгч                 |
| 20. Палам Чимгээ            | - БОЭТ-ийн дотрын тасгийн сувилагч                     |
| 21. Энх-Амгалан Ачитмаа     | - БОЭТ-ийн шинжилгээний тасгийн<br>сувилагч            |
| 22. Бэхнээ Наранхүү         | - БОЭТ-ийн сэтгэц наркологийн тасгийн их<br>эмч        |
| 23. Содномдовжид Дариймаа   | - БОЭТ-ийн мэдрэлийн тасгийн сувилагч                  |
| 24. Цэвэгжав Төмөрхүү       | - БОЭТ-ийн дүрс оношлогооны тасгийн<br>рентген техникч |
| 25. Гүцэв Оюунцэцэг         | - БОЭТ-ийн халдвартын тасгийн их эмч                   |
| 26. Дагважанцан Лувсан-Очир | - Чандмань сумын ахмад настан                          |
| 27. Суманхөх Басан          | - Үенч сумын ахмад настан                              |

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 81


Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсын 2 дугаар их хурлаар 1925 онд Чандмань уулын аймгийн төв Ховд хотноо байгуулагдаж Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 194 дүгээр тогтоолоор Бүсийн оношлогоо Эмчилгээний төв болж өргөжин баруун бүс нутгийн ард иргэдэд үйлчлэх хүрээ нь өргөжин, үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байгаа Ховд аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийг Эрүүл мэндийн байгууллага үүсэж хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан эрүүл мэндийн салбарт оруулсан хувь нэмрийг нь үнэлж Монгол Улсын Төрийн дээд шагнал "Алтан гадас одон"-гоор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 23 өдөр

Дугаар 82

Ховд

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “з” заалт , Аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Байгалийн давагдашгүй хүчин зүйл, хүний буруутай үйл ажиллагааны улмаас эвдэрч, доройтсон, унаган төрх байдлаа алдсан газруудад нөхөн сэргээлт хийх зорилгоор “Хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийхэд хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлэн хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 23 өдөр

Дугаар 84

Ховд

Нэрэмжит болгох тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол улсын хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавъяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг мөнхжүүлэх журам”-ын 6.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2015 оны 1/1618 тоотой ирүүлсэн саналыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймагт Эрүүл мэндийн байгууллага үүсэж хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан Бүсийн оношлогоо эмчилгээний төвийг Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Ардын эмч Начингийн Баасанжавын нэрэмжит болгосугай.

2. Бүсийн оношлогоо эмчилгээний төвийг Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Ардын эмч Н.Баасанжавын нэрэмжит болгосон шийдвэрийг олон нийтэд сурталчилан таниулахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Н.Бөхболд/, аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/ нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 23 өдөр

Дугаар 85

Ховд


Хүндэт иргэнээр шагнах тухай

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 131 дүгээр тогтоолоор баталсан “Аймгийн шагналын журам”, аймгийн Засаг даргын 2015 оны 1/1642 тоотор ирүүлсэн саналыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол улсын нэрийг тив, дэлхийд дуурсгасан бөхчүүдийг бэлтгэж, Үндэсний их бахархал хүчит бөхийн барилдааны торгон ногоон дэвжээнээ аймаг, орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөн Монгол улсын заан цолыг хүртэж, олон арван улсын заан, харцага, начин цолтнуудыг төрүүлсэн Ховд аймгийн Чандмань сумын харъяат багш, дасгалжуулагч Чадраабалын Бямбадоржийг аймгийн “Хүндэт иргэн”-ээр өргөмжилж шагнасугай.

2. Ч.Бямбадоржид аймгийн “Хүндэт иргэн” шагналын гэрэгэ дагалдах мөнгөн шагналыг ёслол хүндэтгэлтэй гардуулах үйл ажиллагааг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр нийтэд сурталчилахыг аймгийн ИТХ-ын Ажлын алба, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 23 өдөр

Дугаар 86

Ховд

Г Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Алтан гадас одон”-гоор

- |                          |                                                |
|--------------------------|------------------------------------------------|
| 1. Даваа Саранцэцэг      | - Нийтийн номын сангийн ахлах номын санч       |
| 2. Чирчинжав Хайрт       | - Буянт сумын Норжинхайрхан багийн иргэн       |
| 3. Лувсанням Юнгэрэндорж | - Буянт сумын Наранхайрхан багийн ахмад настан |
| 4. Баасандорж Дулам      | - Буянт сумын Наранхайрхан багийн ахмад Настан |

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар

- |                      |                                         |
|----------------------|-----------------------------------------|
| 1. Банзрагч Зуунболд | - Цаст-Алтайн жинчид ХХК-ний жолооч     |
| 2. Бавуу Нямдорж     | - ХИС-ийн Түүх эрх зүйн тэнхмийн багш   |
| 3. Лувсан Нямсүрэн   | - ХИС-ийн Түүх эрх зүйн тэнхмийн багш   |
| 4. Дамдин Лхагвадорж | - Зэрэг сумын Бураа багийн иргэн        |
| 5. Гаанжуур Батхуяг  | - Ховд ЦТС ХХК-д шугам сүлжээний монтёр |
| 6. Жалчинжав Батсүх  | - Ховд Эрч Хүч ОНӨААТҮГ-ын цэцэрлэгч    |

- |                           |                                           |
|---------------------------|-------------------------------------------|
| 7. Дамдинжав Чулуунбаатар | - ОНӨААТҮГ-ын цэцэрлэгч усжуулагч         |
| 8. Гонгоржав Батжаргал    | - Жаргалант сумын Алагтолгой багийн иргэн |
| 9. Лхагва Ганбат          | - Жаргалант сумын Алагтолгой багийн иргэн |
| 10. Догсом Цэдэндамба     | - Жаргалант сумын Тахилт багийн иргэн     |

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 23 өдөр

Дугаар 87

Ховд


Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр  
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны “Аймгийн шагналын журам” батлах тухай 131 дүгээр тогтоолын 1.3.4, 4.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнасугай. Үүнд:

- |                          |                                                                     |
|--------------------------|---------------------------------------------------------------------|
| 1. Даржаа Лхавгаа        | - Чандмань сумын ахмад настан                                       |
| 2. Лханаа Алтангэрэл     | - Чандмань сумын иргэн                                              |
| 3. Дэлэгсамбуу Лхамсүрэн | - Чандмань сумын иргэн                                              |
| 4. Бат-Эрдэнэ Бумбаа     | - Чандмань сумын иргэн                                              |
| 5. Дарьсүрэн Энхээ       | - Чандмань сумын Баянхайрхан багийн эмч                             |
| 6. Дашням Батсуурь       | - Чандмань сумын Тахилт багийн малчин                               |
| 7. Пүрэв Түмэннасан      | - Чандмань сумын иргэн                                              |
| 8. Дамдин Эрдэнэбалсүрэн | - Зэрэг сумын уугуул, Дээд шүүхийн гишүүн                           |
| 9. Даваа Цэцгээ          | - Жаргалант сумын уугуул, Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвийн эмч |
| 10. Төмөрбаатар Сэргэлэн | - Жаргалант сумын уугуул, Ник ХХК-ний инженер                       |

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 23 өдөр

Дугаар 88

Ховд

Бага оврын трактор гэрээлэн авах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Өвөлжилтийн бэлтгэл хангах, хадлан тэжээлийн нөөц бүрдүүлэхэд техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор үнийг нь орон нутгийн хөгжлийн сангаас 3 жилд тэнцүү хувааж төвлөрүүлэх нөхцөлтэйгээр аймгуудад нийлүүлэгдэж байгаа бага оврын тракторыг гэрээлэн авахыг зөвшөөрсүгэй.

2. Гэрээлэн авсан бага оврын тракторыг иргэд, аж ахуйн нэгжид олгох, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг тэнцүү хувааж төвлөрүүлэх, буцаах журмыг зохих хууль тогтоомжийн хүрээнд боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д даалгасугай

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 89


Ховд

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийг Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны “Урамшууллын журам батлах тухай” 183 дугаар тогтоолын 2 дугаар заалтын “Урамшуулалд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэн...” гэснийг “...Урамшуулалд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан Ховд аймгийн “Аварга” хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрээс шийдвэрлэн...” гэж өөрчлөн найруулсугай.

ХУРАЛ ДАРГАЛСАН



М.АМАРСАНАА





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 90

Ховд

Тогтоол хүчингүй болгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, хэвлэлийн мэдээлэлийн эрх чөлөөний тухай хуулийн 4 дүгээр зүйл, олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн хэвлэл мэдээлэлийн хараат бус бие даасан байдлыг хангах зорилгоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2000 оны “Нийтийн мэдээлэлийн төв байгуулах тухай” 73 дугаар тогтоол, 2007 оны “Олон нийтийн статустай, орон нутгийн “Ховд телевиз” болгох тухай 17 дугаар тогтоолыг тус тус 2015 оны 7 дугаар сарын 2-ны өдрөөс хүчингүй болгосугай.


2. Орон даяар телевизийн өргөн нэвтрүүлгийн аналог системийг энэ оны долдугаар сарын 15-наас аравдугаар сарын 5-ны хооронд унтрааж, тоон системд шилжиж байгаатай холбогдуулан олон нийтийн статустай орон нутгийн “Ховд телевиз”-д ашиглаж байгаа техник, тоног төхөөрөмжүүд цаашид ашиглах боломжгүй болон сэлбэж өөрчлөх шаардлагатай болсон тул орон нутгийн өмчлөлийн хөрөнгүүдийг тус телевизийн мэдэлд шилжүүлсүгэй.

3. Аймгийн нутгийн удирдлагын байгууллагуудын дэмжлэг, уран бүтээлчдийн санаачлага, иргэдийн оролцоотой бий болсон аймгийн орон нутгийн анхны “ХоТВ” телевизийн бүрдсэн материаллаг бааз, боловсон хүчний нөөцийн боломж, хэрэглэгчдийн хүрээг тогтвортой хадгалан, техникийн шинэчлэл хийж олон нийтэд үзүүлэх телевизийн үйлчилгээг тасралтгүй үргэлжлүүлэн өргөжүүлж ажиллахыг “Ховд телевиз”-ийн захирал /Н.Баасанжав/-т зөвлөсүгэй.

4. Тус тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Н.Бөхболд/-д үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛСАН

М.АМАРСАНАА





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 91

Ховд


Хөрөнгө ашиглалтаас хасах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3.3, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын 2013 оны 30 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.2, "Шим ус" ОНӨААТҮГ-ын 2015 оны 1/115 тоотор ирүүлсэн хүсэлт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ашиглалтын явцад элэгдэж хуучирсан, цаашид ашиглах үр ашиггүй болсон, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 23, 54 дүгээр тогтоолоор нийтэд зарласан дуудлагын худалдаагаар борлогдоогүй аймгийн "Шим ус" ОНӨААТҮГ-ын дансанд бүртгэлтэй Жаргалант сумын баатархайрхан багт байрлах 2001 онд ашиглалтанд орсон, 2855,0 мянган төгрөгийн балансын үнэ бүхий гэр хороололын ус түгээх цэгийн барилгыг 500,0 мянган төгрөгөөр худалдан авах санал ирүүлсэн, ашиглалтыг хариуцан ажиллаж байсан Жаргалант сумын баатархайрхан багийн иргэн /П.Эрдэнэбулган/-д худалдаж данснаас хасахыг "Шим ус" ОНӨААТҮГ-ын захирал /Д.Нямлхагва/-т зөвшөөрсүгэй

2. Хөрөнгийг борлуулсан орлогыг аймгийн өмчийн сангийн дансанд төвлөрүүлэн, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны ЭЗҮӨХХэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛСАН



М.АМАРСАНАА



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 92

Ховд

Хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан журмын 4 дүгээр зүйлийн 4.1 дэхь заалт, Буянт сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн 37 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 21-07/050/101 дүгнэлт, Булган сумын 1 дүгээр сургуулийн захирлын санал, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Булган сумын 12 жилийн 1 дүгээр дунд сургуулийн балансад бүртгэлтэй Буянт сумын хүүхдийн цэцэрлэгийн балансад шилжүүлэх хөрөнгийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Байгууллагаас хөрөнгийг хүлээлцүүлэх ажлын хэсгийг томилж зохих журмын дагуу хүлээлцүүлэн бүртгэлээс хасахыг Булган сумын 12 жилийн 1 дүгээр дунд сургуулийн захирал /С.Баярсайхан/-д зөвшөөрч, хөрөнгийг хүлээн авах комиссыг томилон бүртгэлд авч ашиглалтыг хариуцаж ажиллахыг Буянт сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч /Г.Бадамхорлоо/-д үүрэг болгосугай.


3. Тус тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны Эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛСАН

М.АМАРСАНАА



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны  
... дугаар тогтоолын хавсралт



Данс бүртгэлээс хасч шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

/төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Худалдах хөрөнгийн марк	Ашиглалтанд орсон он	Тоо	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Үнийн санал
1	Булган сумын 1 дүгээр сургууль	DONGPING	2011	1	2500	2500	2500	0	



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 93

Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 дахь заалт, Мянгад сумын ИТХ-ын даргын 1/41 тоот хүсэлт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн 2015 оны төсвийн хөрөнгөөр Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын албан ажлын хэрэгцээнд Япон улсад 1995 онд үйлдвэрлэсэн 2007 онд Монгол улсад орж ирсэн Toyota Landcruiser 80 маркийн, HDJ810061744 арлын дугаартай, мөнгөлөг өнгийн, 64-64 УБЛ улсын дугаартай 25000.0 мянган төгрөг / хорин таван сая/-ийн үнэ бүхий авто машиныг Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэхийг Тамгын газрын дарга /Ч.Улаанхүү/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийн бүртгэлд тусгаж, хөрөнгийн ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын албаны Эдийн засаг үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛСАН

М.АМАРСАНАА





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 94

Ховд


Хөрөнгө бүртгэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 дахь заалт, Дөргөн сумын Засаг даргын 1/208 тоот хүсэлт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн 2015 оны төсвийн хөрөнгөөр Дөргөн сумын Засаг даргын Тамгын газрын албан ажлын хэрэгцээнд 1996 онд үйлдвэрлэсэн 2011 онд Монгол улсад орж ирсэн Toyota Landcruiser 80 маркийн, HDJ810064896 арлын дугаартай, ногоон өнгийн, 33-85 УНО улсын дугаартай 25000.0 мянган төгрөг /хорин таван сая/-ийн үнэ бүхий суудлын авто машиныг Дөргөн сумын Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэхийг Тамгын газрын дарга /Л.Цэдэн-Иш/-д зөвшөөрсүгэй.

2. Тус тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын албаны Эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛСАН



М.АМАРСАНАА



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 05

Ховд


Хөрөнгө бүртгэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 дахь заалт, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны 2015 оны 7 дугаар сарын 8-ний өдрийн 1/17 албан тоотоор ирүүлсэн санал, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын төсвийн хөрөнгөөр Үенч сумын ИТХ-ын албан ажлын хэрэгцээнд авсан Япон улсад 2003 онд үйлдвэрлэсэн 2015 онд Монгол улсад ож ирсэн. Toyota-Estima маркийн, ahr102005773 арлын дугаартай, цагаан өнгийн, ХОУ36-88 улсын дугаартай 8200.0 мянган төгрөг / Найман сая хоёр зуун мянган төгрөг /-ийн үнэ бүхий суудлын авто машиныг Үенч сумын ИТХ-ын балансад бүртгэж авахыг сумын Тамгын газрын дарга /Э.Батзаяа /-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийн бүртгэлд тусгаж, хөрөнгийн ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны Эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга / Ч.Багдал /-д үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛСАН



М.АМАРСАНАА



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 96

Ховд

Зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн "г", 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл, "Шим ус" ОНӨААТҮГ-ын 2015 оны 101 тоотор ирүүлсэн хүсэлт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. "Шим ус" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны алдагдалыг буруулах, орон нутгийн өмчийн ашиглалт, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор тус байгууллагын эзэмшилд буй Жаргалант сумын Рашаант багийн 3 хүний халуун усны барилгыг Буянт багийн 8 хүний халуун усны барилгатай, Цамбагарав багийн 4 хүний халуун усны барилгыг Тахилт багийн 5 хүний халуун усны барилгатай тус тус нэг багц болгон тухайн нэгжид ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн хамт түрээсийн гэрээнд шилжүүлэн, түрээсийн жилийн төлбөрийг тухайн түрээслэж буй хөрөнгийн жилд байгуулах элэгдэлийн хэмжээнээс багагүй байхаар тогтоож гэрээ байгуулж ажиллахыг "Шим ус" ОНӨААТҮГ-ын захирал /Д.Нямлхагва/- т зөвшөөрсүгэй.

Хоёр. "Шим ус" ОНӨААТҮГ-ын түрээсэнд шилжүүлэх хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав. "Шим ус" ОНӨААТҮГ-ын захирал /Д.Нямлхагва/- т ДААЛГАХ нь:

3.1. Багц бүрийн түрээсийн гэрээг зөвхөн тухайн халуун усны нэгжид ажиллаж буй ажилтануудад зохих хууль тогтоомжийн хүрээнд байгуулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ЭЗҮӨХХэлтэст бүртгүүлэн мөрдөх



3.2. Хөрөнгийг түрээслэхэд халуун усны барилгын зориулалт, үндсэн үйл ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ариун цэвэр, эрүүл ахуйн стандартыг алдагдуулахгүйгээр шинэ ажил үйлчилгээг нэвтэрүүлэх

3.3. Түрээсийн үйл ажиллагаанд шилжүүлж буй халуун усны нэгжид ажиллаж байгаа ажилтануудын ажлын байрыг бүрэн хадгалах

3.4. Түрээслэж буй хөрөнгийг бусад этгээдэд давхар түрээслэхгүй байх

3.5. Түрээсийн гэрээг жил бүр дүгнэж үр дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан, аймгийн Засаг даргад танилцуулж шаардлагатай нөхцөлд өөрчлөлт оруулж байх

3.6. Түрээслэж буй хөрөнгийн чанар, ашиглалтыг дордуулахгүй байхаар үр дүнг хянаж байх тогтоолцоог бүрдүүлж ажиллах

3.7. Түрээслэж буй байгууламж, тоног төхөөрөмж, хөрөнгийн хэвийн үйл ажиллагааг хангах, үр ашгийг дээшлүүлэн менежментийг сайжруулах талаар түрээслэгчдийг мэдээлэл, мэргэжил арга зүйгээр хангаж шаардлагатай засвар үйлчилгээг хийхэд дэмжлэг туслалцаа үзүүлж хамтарч ажиллах


Дөрөв. Түрээсийн хэлбэрт шилжүүлж буй халуун уснуудын хөрөнгийн ашиглалт, иргэдэд үзүүлэх ажил үйлчилгээний хэвийн ажиллагааг тогтвортой хангахад үзүүлэх мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтын ажлыг “Шим ус” ОНӨААТҮГ-ын захиралд хариуцуулан түүнтэй байгуулсан үр дүнгийн гэрээнд тусган дүгнэж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д үүрэг болгосугай.

Тав. Халуун усны салбарын түрээсийн гэрээтэй уялдан “Шим ус” ОНӨААТҮГ-ын 2015 оны батлагдсан санхүүгийн төлөвлөгөөнд орох өөрчлөлтийг тусган шинэчлэн боловсруулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд 2015 оны 9 дүгээр сард багтаан оруулж батлуулахыг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ө.Түвдэндорж/-д үүрэг болгосугай.

Зургаа. Түрээслэгчтэй байгуулах түрээсийн гэрээг хянаж зохих хууль тогтоомжид нийцүүлэн бүртгэж хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг бүтэн жилээр дүгнэн жил бүрийн аймгийн өмчийн тайланд тусган аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн

хуралдаан болон аймгийн Засаг даргад танилцуулж ажиллахыг аймгийн ИТХ-ын  
Тэргүүлэгчдийн ЭЗҮӨХХ-ийн дарга /Ч.Багдал/-д даалгасугай.

ХУРАЛ ДАРГАЛСАН



М.АМАРСАНАА

"ШИМ УС" ОНӨААТҮГ-ЫН ТҮРЭЭСЭНД ШИЛЖҮҮЛЭХ

ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ



ДД	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Анхны өртөг /мян.төг/	Хуримтлагдсан элэгдэл /мян.төг/	Үлдэх өртөг /мян.төг/	Байршил
0	1	2	3	4	5	6
I	<b>1.Буянт баг</b>					
	1.1. 8 хүний халуун усны барилга	2012	70000,0	2338,0	67662,0	Буянт багийн нутагт байрлах 8415510048 нэгж талбарын дугаар бүхий 1082,3 м <sup>2</sup> газар эзэмших эрхийн 0235680 дугаарын гэрчилгээтэй 8 хүний хүчин чадалтай халуун усны барилга
	1.2. Кассын машин	2013	515,1	206,1	309,0	
	1.3. Халаалтын тогоо 450м <sup>2</sup> /БҮТЭЗ/		580,0	0,0	580,0	
	1.4. Үсчингийн хүлээлгийн цэнхэр сандал 6 ширхэг /БҮТЭЗ/		30,0	0,0	180,0	
	1.5. Үсчин тавиур /БҮТЭЗ/		150,0	0,0	150,0	
	<b>2. Рашаант баг</b>					
	2.1. 3 хүний халуун усны барилга	2001	8109,2	1892,7	6216,5	Рашаант багийн нутагт байрлах 8414700297 нэгж талбарын дугаар бүхий 0,11 га газар эзэмших эрхийн 0234542 дугаарын гэрчилгээтэй 3 хүний хүчин чадалтай халуун усны барилга
	2.2. 3 хүний халуун усны хашаа	2001	1954,8	1824,6	130,2	
	2.3. 3 хүний халуун усны цооног	2002	11324,0	9814,9	1509,1	
	2.4. Гар насостой ус түгээх цэг	2001	238,5	55,7	182,8	
	2.5. Кассын машин	2013	515,1	206,1	309,0	
	2.6. Үсний тавиур /БҮТЭЗ/		120,0	0,0	120,0	
	2.7. 220В халаалтын насос /БҮТЭЗ/		140,0	0,0	140,0	
	2.8. Пийшийн /худаг/ /БҮТЭЗ/		45,0	0,0	45,0	
II	<b>1.Тахилт /Алагтолгой/ баг</b>					Тахилт /Алагтолгой/ багийн нутагт байрлах 8413300294 нэгж талбарын дугаар бүхий 0,18 га газар эзэмших эрхийн 0234541 дугаарын гэрчилгээтэй 5 хүний хүчин чадалтай халуун усны барилга
	1.1. 5 хүний халуун усны барилга	2001	8109,2	1892,7	6216,5	
	1.2. 5 хүний халуун усны хашаа	2001	1954,8	1824,6	130,2	
	1.3. 5 хүний халуун усны цооног	2001	13242,6	12380,6	882,0	
	1.4. Гар насостой ус түгээх цэг	2001	238,5	55,7	182,8	
	1.5. Кассын машин	2013	515,1	206,1	309,0	
	1.6. УТЦ-ийн зуух /пийшин/ /БҮТЭЗ/		74,0		74,0	

1	2	3	4	5	
1.7. Үсчингийн хүлээлгийн сандал /БҮТЭЗ/		30,0		30,0	Цамбагарав багийн нутагт байрлах 8414110113 нэгж талбарын дугаар бүхий 250 м <sup>2</sup> газар эзэмших эрхийн 0234517 дугаарын гэрчилгээтэй 4 хүний хүчин чадалтай халуун усны барилга
1.8. Хүлээлгийн сандал 4 ширхэг /БҮТЭЗ/		150,0		600,0	
1.9. Үсчингийн уурын аппарат /БҮТЭЗ/					
1.10. Үсний тавиур /БҮТЭЗ/					
1.11. Үсчингийн өлгүүр /БҮТЭЗ/					
1.12. Үсчингийн толь /БҮТЭЗ/					
1.13. Халуун усны өлгүүр /БҮТЭЗ/					
1.14. Халуун усны толь /БҮТЭЗ/					
1.15. Өрөөний сандал 1м /БҮТЭЗ/					
<b>2. Цамбагарав багийн халуун ус</b>					
2.1. 4 хүний халуун усны барилга	2012	57000,0	1903,8	55096,2	
2.2. 4 хүний халуун усны нүүрс хадгалах угсармал амбаар	2013	1350,0	157,6	1192,4	
2.3. 4 хүний халуун усны хашаа	2013	1716,0	321,8	1394,3	
2.4. Кассын машин	2013	515,1	206,1	309,0	
2.5. Төмөр шкаф	2011	187,0	130,9	56,1	

.....оо.....



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 97

Ховд

Дуудлага худалдаа зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах, дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалт аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Манхан сумын ЗДТГ-ын балансад бүртгэлтэй 12,087,900 төгрөг /Арван хоёр сая наян долоон мянга есөн зуун /-ийн үнэтэй, үлдэх өртөггүй УАЗ-315122 маркын ХОА 24-03 улсын дугаартай суудлын авто машины нийтийн дуудлага худалдаагаар худалдах доод үнийг 1500.0 мянган төгрөг / Нэг сая таван зуун мянган /-өөр тогтоосугай.

2. Нийтийн дуудлага худалдааг 2015 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр аймгийн нутгийн удирдлагын ордонд зохион байгуулсугай.

3. Нийтийн дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдээлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын албаны эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛСАН

М.АМАРСАНАА





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 98

Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 дахь заалт, Буянт сумын Засаг даргын 1/184 тоот хүсэлт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн 2015 оны төсвийн хөрөнгөөр Буянт сумын Засаг даргын Тамгын газрын албан ажлын хэрэгцээнд 2000 онд үйлдвэрлэсэн 2011 онд Монгол улсад орж ирсэн Toyota Landcruiser 100 маркийн, JT111JA008017554 арлын дугаартай, ногоон өнгийн, 00-68 ХОУ улсын дугаартай 30000.0 мянган төгрөг /гучин сая/-ийн үнэ бүхий суудлын авто машиныг Буянт сумын Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэхийг Тамгын газрын дарга /Ш.Даваатогтох/-д зөвшөөрсүгэй.

2. Тус тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын албаны Эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛСАН



М.АМАРСАНАА



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 99

Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 дахь заалт, Манхан сумын Засаг даргын 1/199 тоот хүсэлт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн 2015 оны төсвийн хөрөнгөөр Манхан сумын Засаг даргын Тамгын газрын албан ажлын хэрэгцээнд Япон улсад 2008 онд үйлдвэрлэсэн 2011 онд Монгол улсад орж ирсэн Toyota Landcruiser 80 маркийн, HDJ810040279 арлын дугаартай, мөнгөлөг өнгийн, 05-08 УНД улсын дугаартай 24980.0 мянган төгрөг /хорин дөрвөн сая есөн зуун наян мянган/-ийн үнэ бүхий суудлын авто машиныг Манхан сумын Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэхийг Тамгын газрын дарга /Т.Лхагвасүрэн/-д зөвшөөрсүгэй.

2. Тус тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын албаны Эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛСАН



М.АМАРСАНАА



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 100

Ховд

Хөрөнгө ашиглалтаас хасах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3.3, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын 2013 оны 30 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.2, Алтай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2015 оны 1/19 тоотоор ирүүлсэн хүсэлт, сумын Өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Ашиглалтын явцад элэгдэж хуучирсан цаашид ашиглах боломжгүй болсон Алтай сумын ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй 2001 онд ашиглалтанд орсон, 4410,0 мянган төгрөгийн балансын үнийг элэгдлээрээ бүрэн нөхсөн үлдэгдэл өртөггүй штабын барилга, 1999 онд ашиглалтанд орсон, 1008,0 мянган төгрөгийн балансын үнийг элэгдлээрээ бүрэн нөхсөн үлдэгдэл өртөггүй 1 машины гражийн барилгыг тус тус акталж данснаас хасахыг Алтай сумын ЗДТГ-ын дарга /Д.Баатарсүрэн/-д зөвшөөрсүгэй

2. Акталж данснаас хасч буй хөрөнгөөс ашиглаж болох материалыг сумын өмч хамгаалах зөвлөлөөс үнэ тогтоон борлуулж сумын төсөвт оруулахыг Алтай сумын ЗДТГ-ын дарга /Д.Баатарсүрэн/, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, өмч хамгаалах зөвлөлийн дарга /Г.Гантуяа/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ЭЗҮӨХХэлтсийн дарга /Ч.Багдал/-д даалгасугай

ХУРАЛ ДАРГАЛСАН

М.АМАРСАНАА





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 101

Ховд

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах, дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4 дэхь заалтууд болон аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны “нийтийн дуудлага худалдаа зарлах тухай” 76 дугаар тогтоолоор зарласан нийтийн дуудлага худалдаагаар борлогдоогүй Алтай сумын ЗДТГ-ын балансад бүртгэлтэй 1980 онд ашиглалтанд орсон, 3780,0 мянган төгрөгийн балансын үнийг элэгдлээрээ бүрэн нөхсөн үлдэгдэл өртөггүй складын барилгыг анхны тогтоосон худалдах доод үнэ 500,0 мянган төгрөг /таван зуун мянган/-өөр худалдахаар дахин нийтийн дуудлагын худалдаа зарласугай.

2. Нийтийн дуудлага худалдааг 2015 оны 9 дугаар сарын 7-ны өдөр Алтай сумын ЗДТГ-ын байранд зохион байгуулсугай.

3. Нийтийн дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдээлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын албаны Эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛСАН

М.АМАРСАНАА







ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 102

Ховд

Хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан журмын 4 дүгээр зүйлийн 4.1 дэхь заалт, аймгийн цагдаагийн газрын даргын 2015 оны 47-2/1517 тоот хүсэлт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн цагдаагийн газрын балансад 2010 онд бүртгэсэн 1986 онд аж ахуйн аргаар баригдсан 13,9 сая төгрөгийн балансын үнэтэй 3,9 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй конторын барилгыг Буянт сумын ЗДТГ-ын балансад шилжүүлсүгэй.

2. Байгууллагаас хөрөнгийг хүлээлцүүлэх ажлын хэсгийг томилж зохих журмын дагуу хүлээлцүүлэн хөрөнгийг бүртгэлээс хасахыг аймгийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа /С.Цэрэнсамбуу/-д зөвшөөрч, хөрөнгийг хүлээн авах комиссыг томилон бүртгэлд авч ашиглалтыг хариуцаж ажиллахыг Буянт сумын ЗДТГ-ын дарга /Ш.Даваатогтох/-т үүрэг болгосугай.

3. Тус тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны Эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛСАН

М.АМАРСАНАА





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 103

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:


“Алтан гадас одон”-гоор

1. Дандан Наранжав - Буянт сумын ахмад настан

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар

1. Доржготов Цагаан - БОЭТ-ийн дотрын тасгийн сувилагч

ХУРАЛ ДАРГАЛСАН



М.АМАРСАНАА



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2014 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 104

Ховд


Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр  
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны “Аймгийн шагналын журам” батлах тухай 131 дүгээр тогтоолын 1.3.4, 4.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнасугай. Үүнд:

- |                      |                                                      |
|----------------------|------------------------------------------------------|
| 1. Гүнчин Батдорж    | - Гурвалжин хоршоо Харуул хамгаалалтын албанд харуул |
| 2. Чахай Адараш      | - Гурвалжин хоршоо Харуул хамгаалалтын албанд харуул |
| 3. Самдан Батхүү     | - Гурвалжин хоршоо Харуул хамгаалалтын албанд харуул |
| 4. Мишиг Дашзэвэг    | - Гурвалжин хоршоо Харуул хамгаалалтын албанд харуул |
| 5. Цэдэнпил Банзрагч | - Гурвалжин хоршоо Харуул хамгаалалтын албанд харуул |

ХУРАЛ ДАРГАЛСАН



М.АМАРСАНАА



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 105

Ховд

Дэмжих тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн болон орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны төсөв, хөрөнгө оруулалтын 2016 оны төсвийн төсөл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн талаархи аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, Засаг даргын өргөн мэдүүлсэн саналыг дэмжсүгэй.

2. Тус төсвийн төсөл, төсөөллийг боловсруулах болон хэлэлцэх явцад аймгийн ИТХ-ын Төлөөлөгчид, Тэргүүлэгчдээс гарсан саналыг тусган холбогдох яамдад өргөн мэдүүлж улсын нэгдсэн төсөвт тусгуулах арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 106

Ховд

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах, дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4 дэхь заалтууд болон аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны “нийтийн дуудлага худалдаа зарлах тухай” 63 дугаар тогтоолоор зарласан нийтийн дуудлага худалдаагаар борлогдоогүй аймгийн цагдаагийн газрын балансад бүртгэлтэй 2007 онд ашиглалтанд орсон, 11295,0 мянган төгрөгийн балансын үнийг элэгдлээрээ бүрэн нөхсөн үлдэгдэл өртөггүй УАЗ-22069-033 маркийн 23-99 ХОА дугаартай Фургон автомашиныг анхны тогтоосон худалдах доод үнэ 1000,0 мянган төгрөг / нэг сая /-өөр худалдахаар дахин нийтийн дуудлагын худалдаа зарласугай.

2. Нийтийн дуудлага худалдааг 2015 оны 8 дугаар сарын 24-ны өдөр аймгийн нутгийн удирдлагын ордонд зохион байгуулсугай.

3. Нийтийн дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдээлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын албаны эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 107

Ховд

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах, дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4 дэхь заалтууд болон аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны “нийтийн дуудлага худалдаа зарлах тухай” 63 дугаар тогтоолоор зарласан нийтийн дуудлага худалдаагаар борлогдсон боловч худалдан авагч үнийг нь хугацаандаа хийгээгүй Мянгад сумын ЗДТГ-ын балансад бүртгэлтэй 2007 онд ашиглалтанд орсон, 12820,5 мянган төгрөгийн балансын үнийг элэгдлээрээ бүрэн нөхсөн үлдэгдэл өртөггүй УАЗ-315122-410 маркийн 24-04 ХОА дугаартай суудлын автомашиныг анхны тогтоосон худалдах доод үнэ 1500,0 мянган төгрөг / нэг сая таван зуун мянга/-өөр худалдахаар дахин нийтийн дуудлагын худалдаа зарласугай.

2. Нийтийн дуудлага худалдааг 2015 оны 8 дугаар сарын 24-ны өдөр аймгийн нутгийн удирдлагын ордонд зохион байгуулсугай.

3. Нийтийн дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдээлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын албаны эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 108

Ховд


Зөвшөөрөл сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 18 дугаар тогтоолоор баталсан “Ховд аймгийн нутаг дэвсгэрт Шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”-ыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын Жаргалан багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Ивээлт баярын мэдээ Христийн чуулган”-ны үйл ажиллагаа явуулах эрхийг 2017 оны 08 дугаар сарын 08 -нийг хүртэл 2 жилийн хугацаатайгаар сунгасугай.

2. Үйл ажиллагаандаа “Ховд аймгийн нутаг дэвсгэрт Шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”-ыг удирдлага болгон ажиллахыг “Ивээлт баярын мэдээ Христийн чуулган”-ны ахлагч /Б.Энхчимэг/-т зөвлөсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 109

Ховд


Нэрэмжит болгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 20 дугаар зүйлийн 20.1.12, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавъяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг мөнхжүүлэх журам”-ын 6.4 дэх заалт, аймгийн Засаг дарга болон Буянт сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын саналыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Буянт сумын уугуул Монгол улсын Гавъяат жүжигчин Сандагийн Мэндээгийн жүжигчний урлагыг хадгалан хамгаалах, хойч үедээ өвлүүлэн хөгжүүлэх, гавъяат үйлсийг алдаршуулан дурсгалыг мөнхжүүлэх зорилгоор Буянт сумын Соёлын төвийг Монгол улсын гавъяат жүжигчин Сандагийн Мэндээгийн нэрэмжит болгосугай.

2. Тус сумын соёлын төвийг Монгол улсын гавъяат жүжигчин Сандагийн Мэндээгийн нэрэмжит болгосон шийдвэрийг олон нийтэд сурталчлан таниулах, соёлын салбарт өв уламжлалыг хөгжүүлэх үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 110

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

Монгол улсын “Хүний гавъяат эмч цол”-оор

1. Бэгз Жамсран - “Ач заяа” эмнэлгийн зөвлөх эмч

Монгол улсын “Гавъяат багш цол”-оор

1. Доржхүү Баттулга - Жаргалант сумын Магсаржав багийн иргэн

“Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-гоор

1. Солом Алтангэрэл - Мөст сумын Баянхайрхан багийн иргэн
2. Ноосгой Баатарсүрэн - Жаргалант сумын 12 жилийн 3 дугаар сургуулийн математикийн багш

“Алтан гадас одон”-гоор

1. Пунцаг Дулам - БОЭТ-ийн ахмад ажилтан
2. Чүлтэм Янжмаа - Жаргалант сумын Баатархайрхан багийн ахмад настан

- |                       |                                                 |
|-----------------------|-------------------------------------------------|
| 3. Дарьсүрэн Юнгэрмаа | - Жаргалант сумын Жаргалан багийн иргэн         |
| 4. Биндээ Мөнхөө      | - Жаргалант сумын Наран багийн иргэн            |
| 5. Жавзан Цэвлээ      | - Жаргалант сумын Наран багийн ахмад<br>настан  |
| 6. Далхаа Цэндсүрэн   | - Буянт сумын Нарийн гол багийн ахмад<br>настан |
| 7. Шотай Күлиман      | - Жаргалант сумын Наран багийн ахмад<br>настан  |
| 8. Аръяажав Чадраабал | - Жаргалант сумын Наран багийн<br>ахмад настан  |

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар


- |                          |                                                    |
|--------------------------|----------------------------------------------------|
| 1. Минжүүр Дунгаамаа     | - БОЭТ-ийн ахмад ажилтан                           |
| 2. Пүрэв Морозова        | - Жаргалант сумын Магсаржав багийн<br>ахмад настан |
| 3. Лувсмаа Даваажав      | - Жаргалант сумын Магсаржав багийн<br>ахмад настан |
| 4. Батаа Суманжав        | - Жаргалант сумын Наран багийн иргэн               |
| 5. Балжир Батчулуун      | - Жаргалант сумын Наран багийн иргэн               |
| 6. Баянаа Далантай       | - Жаргалант сумын Наран багийн иргэн               |
| 7. Төртогтох Норов       | - Жаргалант сумын Наран багийн иргэн               |
| 8. Лувсан Должинсүрэн    | - Жаргалант сумын Наран багийн ахмад<br>настан     |
| 9. Хорлоо Жудлаа         | - Жаргалант сумын Бугат багийн ахмад<br>настан     |
| 10. Батаа Тогтох         | - Жаргалант сумын Бугат багийн ахмад<br>настан     |
| 11. Хонгоршар Алтанцэцэг | - Жаргалант сумын Бугат багийн иргэн               |
| 12. Хоожин Оюунаа        | - Жаргалант сумын Алагтолгой багийн<br>иргэн       |
| 13. Ширэндээ Дуламжав    | - Жаргалант сумын Магсаржав багийн<br>иргэн        |

14. Цэрэндаш Нина - Жаргалант сумын Бичигт багийн ахмад настан
15. Төмөрхүү Сайнхүү - Жаргалант сумын Буянт багийн ахмад настан
16. Дамдиндорж Нарангэрэл - Жаргалант сумын Буянт багийн иргэн
17. Алтангэрэл Номинхүү - Жаргалант сумын Буянт багийн ахмад настан

“Шударга журам медаль”-иар

18. Чулуунсүрэн Өлзийсүрэн - Алтай сумын Тахил багийн иргэн

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 111

Ховд

Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр  
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны “Аймгийн шагналын журам” батлах тухай 131 дүгээр тогтоолын 1.3.4, 4.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнасугай. Үүнд:

- |                         |                                                       |
|-------------------------|-------------------------------------------------------|
| 1. Мөнхөө Содномдорж    | - Манхан сумын Ботгон багийн малчин                   |
| 2. Батсуурь Бямбаа      | - Манхан сумын Ботгон багийн малчин                   |
| 3. Рэгзэн Харнүдэн      | - Манхан сумын Ботгон багийн малчин                   |
| 4. Лхагва Болдоо        | - Манхан сумын Ботгон багийн малчин                   |
| 5. Батнасан Гантулга    | - Чандмань сумын байгаль хамгаалагч                   |
| 6. Төөмөө Баяртогтох    | - БОЭТ-ийн захирал                                    |
| 7. Дагва Минжигмаа      | - БОЭТ-ийн ахмад ажилтан                              |
| 8. Лхасүрэн Бадамжав    | - БОЭТ-ийн ахмад ажилтан                              |
| 9. Самдан Норжмаа       | - БОЭТ-ийн ахмад ажилтан                              |
| 10. Шагдар Зээхүү       | - БОЭТ-ийн мэс заслын тасгийн хагалгааны<br>сувилагч  |
| 11. Ууш Цэрэнхүү        | - БОЭТ-ийн мэс заслын тасгийн сувилагч                |
| 12. Ядамжав Эрдэнэцэцэг | - БОЭТ-ийн эмчилгээний хоолны тасгийн<br>ахлах тогооч |

- |                            |                                                           |
|----------------------------|-----------------------------------------------------------|
| 13. Чулуунбат Доржпалам    | - БОЭТ-ийн дүрс оношлогооны тасгийн<br>дурангийн сувилагч |
| 14. Лувсандорж Сосорбарам  | - БОЭТ-ийн чих, хамар хоолойн тасгийн<br>сувилагч         |
| 15. Жаргал Бадамцэцэг      | - БОЭТ-ийн уламжлалт эмчилгээний тасгийн<br>үйлчлэгч      |
| 16. Цэдэндамба Эрдэнэсүрэн | - Ховд эм хангамж Компаний бичиг хэрэг                    |
| 17. Балжир Янжинхорлоо     | - БОЭТ-ийн ахмад ажилтан                                  |
| 18. Агваандаш Энх-Амгалан  | - ЭМГ-ын хүүхдийн ерөнхий мэргэжилтэн                     |
| 19. Дамбий Гантуяа         | - БОЭТ-ийн сэтгэл мэдрэлийн тасгийн асрагч                |
| 20. Түдэв Мөнхцэцэг        | - ЭМГ-ын статистик бага эмч                               |
| 21. Жанчивдорж Нямбаяр     | - ЭМГ-ын мэргэжилтэн                                      |

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 112

Ховд

Ховд аймгийн “Хүндэт иргэн” шагналаар  
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 131 дүгээр тогтоол, Аймгийн шагналын журмын 1 дүгээр зүйлийн 1.3.2, 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтууд, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол оронд ардчилсан, шинэ Үндсэн хууль батлан хэрэгжүүлэх, хууль эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох, төрийн албыг төгөлдөржүүлэх, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэхэд бодит хувь нэмрээ оруулж, Ховд аймгийн эдийн засаг, нийгэм, хүн амын хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад сэтгэл зүтгэл, хөдөлмөрөө зориулан ажиллаж, амжилт гаргасан Ерөнхийлөгчийн Тамгын газрын шагналын тасгийн ахлах референт, Монголын Ардчилсан Холбооны ууган гишүүн Дамдины Чадраабалыг Ховд аймгийн “Хүндэт иргэн” шагналаар шагнасугай.

2. Ховд аймгийн “Хүндэт иргэн” шагналаар шагнагдагдсан алдартны хөдөлмөр бүтээл, гавъяаг нийтэд сурталчилж, энгэрийн тэмдэг, үнэмлэх, дагалдах шагналыг гардуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Б.Баярсайхан/, аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/ нарт зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 114

Ховд

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.2, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах, дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4 дэхь заалтууд болон аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны “Нийтийн дуудлага худалдаа зарлах тухай” 106 дугаар тогтоолоор дахин зарласан дуудлага худалдаагаар борлогдоогүй аймгийн Цагдаагийн газрын балансад бүртгэлтэй 2007 онд ашиглалтанд орсон, 11295,0 мянган төгрөгийн балансын үнийг элэгдлээрээ бүрэн нөхсөн үлдэгдэл өртөггүй УАЗ-22069-033 маркийн 23-99 ХОА дугаартай Фургон автомашиныг анхны тогтоосон худалдах доод үнийг 50,0 хувиар бууруулж 500,0 мянган төгрөг /таван зуун мянга/-өөр худалдахаар дахин нийтийн дуудлагын худалдаа зарласугай.

2. Нийтийн дуудлага худалдааг 2015 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр аймгийн Нутгийн Удирдлагын ордонд зохион байгуулсугай.

3. Нийтийн дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдээлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны Эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 115

Ховд


Төслийг дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.10 дугаар заалт, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын 2015 оны 7/7076, Торгууд өв соёлын холбооны 2015 оны 19 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт болон аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монголын язгуур урлагийн баатарлаг туульсын гол төрөл, соёлын биет бус өв болох Алтайн магтаалыг мөнхжүүлэн, аялал жуучлалын хөгжүүлэхээр “Хан Алтайн дуулал цогцолбор”-ыг барьж байгуулан орон нутгийн өмчлөлд шилжүүлэх санаачилга гаргаж буй олон нийтийн байгууллагуудын саналыг дэмжиж тус цогцолборын суурь болох барилгын хэсгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэн барьж байгуулахыг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д үүрэг болгосугай.

2. “Хан Алтайн дуулал цогцолбор”-ыг барьж байгуулахаар олон нийтийн байгууллагуудас гаргасан санаачилгыг дэмжиж олон нийтэд сурталчлан, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, хамт олон, иргэдэд уриалсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 116

Ховд


Салбар хороод байгуулах тухай

Үндэсний Их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Буянт сумын ИТХ, Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Хүннү гүрэн байгуулагдсаны 2224, Их Монгол улс байгуулагдсаны 809, Ардын хувьсгалын 94, Буянт сум байгуулагдсаны түүхт 90 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах салбар хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Баяр наадмын бэлтгэл ажлыг хангаж, салбар хороодын үйл ажиллагааг уялдуулан ойн арга хэмжээг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэхийг салбар хороодын дарга нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 09 дүгээр сарын  
01-ний өдрийн 11 дугаар тогтоолын  
хавсралт

Хүннү гүрэн байгуулагдсаны 2224, Их Монгол улс байгуулагдсаны 809, Ардын хувьсгалын 94, Буянт сум байгуулагдсаны 90 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах салбар хороодын бүрэлдэхүүн

1. Хурдан морьдын уралдаан зохион байгуулах салбар хороо:

Дарга: Б.Эрдэнэчулуун - Аймгийн Засаг даргын Тамгын газрын цэргийн штабын дарга

Нарийн бичгийн дарга: Б.Ганзориг - Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч

Гишүүн: Н.Ганболд - Аймгийн Цагдаагийн газрын замын цагдаагийн тасгийн дарга

С.Алтансүх - ЗХ-ний 123 дугаар ангийн захирагчийн орлогч

Л.Энхбаяр - Аймгийн ХГБХ-ийн хэлтсийн дарга

Т.Пүрэвжав - Аймгийн ХХААГ-ын мал эмнэлгийн тасгийн дарга

Н.Банзайдорж - Ховд аймгийн "Алтайн унага" уяачдын холбооны тэргүүлэгч

З.Батбулган - БОЭТ-ийн их эмч

М.Ганзориг - Аймгийн "Алтайн унага" уяачдын холбооны тэргүүлэгч

2. Үндэсний Бөхийн барилдаан зохион байгуулах салбар хороо:

Дарга: П.Амгаланбаатар - Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга

Нарийн бичгийн

дарга: Б.Сандагсүрэн - Аймгийн Бөхийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга, гарын даа

Гишүүд: Г.Цэдэнбал - аймгийн Үндэсний бөхийн холбооны тэргүүн

Г.Пүрэвганди - Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч, тайлбарлагч

Б.Шоовдой - Аймгийн ҮБХ-ны тэргүүлэгч, гарын даа  
С.Ганхуяг - Аймгийн Биеийн тамир, спортын газрын Спортын  
хорооны дасгалжуулагч

Ц.Энэбиш- Аймгийн арслан

Б.Загдсүрэн- аймгийн Үндэсний бөхийн холбооны тэргүүлэгч

Б.Батмөнх-аймгийн Үндэсний бөхийн холбооны тэргүүлэгч

3. Сурын харваа зохион байгуулах салбар хороо:

Дарга: Н.Бөхболд - Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга

Нарийн бичгийн  
дарга: Д.Сумъяа - Сурын холбооны нарийн бичгийн дарга

Гишүүд: Ч.Түмэндэмбэрэл - Аймгийн Биеийн тамир, спортын  
газрын спортын сургалт хариуцсан албаны дарга

Д.Октябрь -Аймгийн Цагдаагийн газрын ахлах хэрэг  
бүртгэгч

Б.Баттүвшин - Аймгийн ИТХ-ын ажлын албаны  
мэргэжилтэн



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 117


Ховд

Эмчилгээний зардалд дэмжлэг  
үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт–шинжилгээ, үнэлгээний тасгийн ахлах мэргэжилтэн Х.Дарьгерхан нь магадлан итгэмжлэл бүхий Улсын нэгдсэн төв эмнэлгийн шийдвэрээр хавдрын мэс засал хийлгэж, цаашид эмчлүүлэх шаардлагатай болсон тул Төрийн албаны хууль, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан 10,0 сая төгрөг /арван сая/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 118

Ховд

Ховд аймгийн “Хүндэт иргэн” шагналаар  
шагнах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 131 дүгээр тогтоол, Аймгийн шагналын журмын 1 дүгээр зүйлийн 1.3.2, 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтууд, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол оронд ардчилсан, шинэ Үндсэн хууль батлан хэрэгжүүлэх, хууль эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох, төрийн албыг төгөлдөржүүлэх, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэхэд бодит хувь нэмрээ оруулж, Ховд аймгийн эдийн засаг, нийгэм, хүн амын хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад сэтгэл зүтгэл, хөдөлмөрөө зориулан ажиллаж, амжилт гаргасан Хууль зүйн ухааны доктор, Монгол улсаас АНУ-д суух Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Булгаагийн Алтангэрэл, эх орондоо авто тээвэр, аж үйлдвэрийн тулгын чулууг тавилцан, орчин цагийн авто тээвэр, хүнд үйлдвэрийн салбарын хөгжил дэвшилд техник эдийн засгийн хэмнэлттэй олон шинэ санааг нэвтрүүлсэн, шинийг санаачлагч, ахмад тээвэрчин, Монгол улсын Хөдөлмөрийн баатар Ванчинжавын Данхар, Төрийн соёрхолт, Шинжлэх ухааны доктор, “Эрдэнэт” үйлдвэрийн ерөнхий баяжуулагч, инженер Жамсрангийн Баатархүү, Буянт сумын уугуул, аймгийн арслан Лааганы Найдан нарыг Ховд аймгийн “Хүндэт иргэн” шагналаар шагнасугай.

2. Ховд аймгийн “Хүндэт иргэн” шагналаар шагнагдагсдын алдар гавъяаг нийтэд сурталчилж, энгэрийн тэмдэг, үнэмлэх, дагалдах шагналыг гардуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Б.Баярсайхан/, аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/ нарт зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 120

Ховд

Ховд аймгийн "Хүндэт дэвтэр"-т бичиж  
алдаршуулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.3.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол орныхоо бүтээн байгуулалт, хөгжил цэцэглэлтэнд оюун ухаан, хөдөлмөр бүтээлээ зориулан, цаг үеийнхээ манлайлагч нь байж, орчин цагийн тээвэр холбоо, худалдаа үйлчилгээ, их барилга, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, спорт, боловсролын салбарт бодит хувь нэмрээ оруулсан Монгол улсын Гавъяат уурхайчин Дамбийн Цагаач, Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, Техникийн ухааны доктор Усны-Эхийн Сүхбаатар, Монгол улсын Гавъяат багш, спортын мастер Сэдийн Базар, Төрийн захиргааны ахмад ажилтан Намсрайн Цэдэнхүү, Самбуугийн Дөрвөд, "Ховд Мөнхтүшиг" ХХК-ны захирал, барилгын инженер Мэндээгийн Өлзийхүү, ахмад эмч Жандалын Зэсээ, Буянт сумын Цагаан Эрэг багийн малчин Көжекберийн Ховдбай, Уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн орлогч дарга Булгаагийн Алтанхуяг, Буянт сумын уугуул, МУ-ын Гавъяат жүжигчин Насанбаярын Нэргүйбаатар, Буянт сумын уугуул, Эрдэнэт үйлдвэрийн Уулын баяжуулах фабрикийн Авто тээврийн хэлтсийн дарга Доржготовын Цагаан-Эрдэнэ нарыг Ховд аймгийн "Хүндэт дэвтэр"-т бичиж, алдаршуулсугай.

2. Ховд аймгийн "Хүндэт дэвтэр"-т бичигдсэн алдартнуудыг нийтэд сурталчилж, дурсгалын гэрчилгээ гардуулахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Б.Баярсайхан/, Аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/ нарт зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 121

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-гоор

1. Авирмэд Балдандорж - “Хос цалиг” ХХК-д химич

“Алтан гадас одон”-гоор

1. Молом Мажигсүрэн - Жаргалант сумын 12 жилийн I сургуулийн багш
2. Ойдов Ганхуяг - Баруун бүсийн эрчим хүчний автоматикийн слесарь
3. Нямдэлэг Пэрэнлэй - Ховд аймгийн Нефть хангамжийн станцад жолооч
4. Еэшээ Зоригоо - Ховд нисэх буудалд жолооч

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар

1. Эрдэнэдагва Энхтайван - Жаргалант сумын Бугат багийн иргэн
2. Нацагдорж Төмөрхүү - Жаргалант сумын Наран багийн иргэн

- |                          |                                                      |
|--------------------------|------------------------------------------------------|
| 3. Ширчин Оюунгэрэл      | - Баруун бүсийн эрчим хүчний системд<br>цахилгаанчин |
| 4. Мижид Отгонбаяр       | - Баруун бүсийн эрчим хүчний системд<br>цахилгаанчин |
| 5. Цэдэндорлиг Цэнд-Аюуш | - Баруун бүсийн эрчим хүчний системд<br>цахилгаанчин |
| 6. Дашдорж Пүрэв         | - Баруун бүсийн эрчим хүчний системд<br>цахилгаанчин |

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН